



**ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2025.02.21 № 52  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ОРХОН АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР  
СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Б.МӨНХБАЯР ТАНАА

**2024 оны санхүүгийн тайлангийн  
аудитын тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Баян-Өндөр сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах аудит хийлээ.

Аудитын тайлан, аудитын дүгнэлт болон аудитаар илэрсэн зөрчилд 14,776.8 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлж байна.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.” гэж заасныг хэрэгжүүлж төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 30 хоногийн дотор, төлбөрийн актыг бүрэн барагдуулж, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА





**ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2025.02.21 № 34  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ОРХОН АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР  
СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Б.МӨНХБАЯР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Баян-Өндөр сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/521 дүгээр тушаалаар “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-д өөрчлөлт оруулснаар 2024 онд зөвхөн хоршоонд зээл олгох болсон байна.

**Аудитын гол асуудал**

Тайлант оны урсгал зардлыг өмнөх жилийн зээлийн хүүгийн орлогын 45.6 хувиар, зээл олгох эх үүсвэрийг 400,000.0 мянган төгрөгөөр тогтоосон байна. 2024 онд 2 удаа төсөл сонгон шалгаруулалт зарлаж эхний төсөл сонгон шалгаруулалтаар 2 хоршоонд 150,000.0 мянган төгрөгийн зээл олгосон боловч хоёр дахь төсөл сонгон шалгаруулалтад оролцогч хүсэлт ирүүлээгүй байна.



## **Бусад асуудлын хэсэг**

Хоршоо хөгжүүлэх сангийн 2024 оны гүйцэтгэлийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2025/005/НА-СТА-ОНТС

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Эрдэнэт хот  
2025 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва

Утас: 70353088 Цахим хаяг: [purevlkhagvar@audit.gov.mn](mailto:purevlkhagvar@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Буян-Ундрах

Утас: 70355805 Цахим хаяг: [buyanundrakhb@audit.gov.mn](mailto:buyanundrakhb@audit.gov.mn)

Ахлах аудитор: В.Жавзмаа

Утас: 70350757 Цахим хаяг: [javzmaav@audit.gov.mn](mailto:javzmaav@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3.САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	8
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	9
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	9
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	11
4.1 Ерөнхий зүйл .....	11
4.2 Материаллаг байдал .....	11
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	11
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	11
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	12
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	15

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2025.02.21 № 54  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ОРХОН АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР  
СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Б.МӨНХБАЯР ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Баян-Өндөр сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/521 дүгээр тушаалаар "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-д өөрчлөлт оруулснаар 2024 онд зөвхөн хоршоонд зээл олгох болсон байна.

### Аудитын гол асуудал

Тайлант оны урсгал зардлыг өмнөх жилийн зээлийн хүүгийн орлогын 45.6 хувиар, зээл олгох эх үүсвэрийг 400,000.0 мянган төгрөгөөр тогтоосон байна. 2024 онд 2 удаа төсөл сонгон шалгаруулалт зарлаж эхний төсөл сонгон шалгаруулалтаар 2 хоршоонд 150,000.0 мянган төгрөгийн зээл олгосон боловч хоёр дахь төсөл сонгон шалгаруулалтад оролцогч хүсэлт ирүүлээгүй байна.



### **Бусад асуудлын хэсэг**

Хоршоо хөгжүүлэх сангийн 2024 оны гүйцэтгэлийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  П.ПҮРЭВЛХАГВА





## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,193,318,048.69</u></b>	<b><u>1,230,121,935.03</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	247,216,570.36	422,058,313.03
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	247,216,570.36	422,058,313.03
<b>3122</b>	<b>Гадаад валют</b>	247,216,570.36	422,058,313.03
31221	Төрийн сангийн харилцах	247,216,570.36	422,058,313.03
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	945,602,478.33	808,063,622.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	945,602,478.33	808,063,622.00
3351	Байгууллагаас авах авлага	466,718,871.95	473,631,154.00
	Хувь хүмүүсээс авах авлага	478,883,606.38	334,432,468.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	499,000.00	-
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	499,000.00	-
35420	Аж ахуйн материал	499,000.00	-
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	-	-
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	-	-
39301	Програм хангамж	1,950,000.00	1,950,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,950,000.00)	(1,950,000.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,193,318,048.69</u></b>	<b><u>1,230,121,935.03</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>901,000,000.00</u></b>	<b><u>901,000,000.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	901,000,000.00	901,000,000.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	901,000,000.00	901,000,000.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	901,000,000.00	901,000,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	901,000,000.00	901,000,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>186,210,370.34</u></b>	<b><u>221,706,315.11</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	292,318,048.69	329,121,935.03
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	292,318,048.69	329,121,935.03
51210	Өмнөх үеийн үр дүн	242,848,569.25	291,317,541.48
51220	Тайлант үеийн үр дүн	49,775,549.65	37,804,393.55
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,193,318,048.69</u></b>	<b><u>1,230,121,935.03</u></b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b><u>52,537,549.65</u></b>	<b><u>43,527,168.55</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b><u>52,537,549.65</u></b>	<b><u>43,527,168.55</u></b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	52,537,549.65	43,527,168.55
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	52,537,549.65	43,527,168.55
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,681,085.59	21,179,896.48
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,856,464.06	22,347,272.07
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b><u>2,762,000.00</u></b>	<b><u>5,722,775.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b><u>2,762,000.00</u></b>	<b><u>5,722,775.00</u></b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,762,000.00	5,722,775.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	900,000.00	1,599,000.00
210401	Бичиг хэрэг	300,000.00	400,000.00
210402	Тээвэр шатахуун	600,000.00	700,000.00



210408	Бараа материал акталсны зардал		499,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,862,000.00	4,123,775.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,862,000.00	4,123,775.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	49,775,549.65	37,804,393.55
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	49,775,549.65	37,804,393.55

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	52,537,549.65	43,527,168.55
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	52,537,549.65	43,527,168.55
120	Нийтлэг татварын бус орлого	52,537,549.65	43,527,168.55
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	52,537,549.65	43,527,168.55
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,681,085.59	21,179,896.48
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,856,464.06	22,347,272.07
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (2)	2,762,000.00	5,722,775.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,762,000.00	5,722,775.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,762,000.00	5,722,775.00
2104	Хангамж, бараа материалын зардал	900,000.00	1,100,000.00
210401	Бичиг хэрэг	300,000.00	400,000.00
210402	Тээвэр шатахуун	600,000.00	700,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,862,000.00	4,123,775.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,862,000.00	4,123,775.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	49,925,549.65	38,303,393.55
14	Бусад эх үүсвэр	367,374,322.17	286,538,349.12
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	367,374,322.17	286,538,349.12
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	400,000,000.00	150,000,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	400,000,000.00	150,000,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(32,625,677.83)	136,538,349.12
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	17,299,871.82	174,841,742.67
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	229,916,698.54	247,216,570.36
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	247,216,570.36	422,058,313.03

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	243,848,569.25	243,848,569.25
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(1,306,070,21)	(1,306,070,21)
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	151,915,832.17	151,915,832.17



C07	Тайлант үеийн үр дүн			49,775,549.65	49,775,549.65
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	292,318,048.69	292,318,048.69
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	(1,000,507,21)	(1,000,507,21)
D01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	0.00	0.00	291,317,541.48	291,317,541.48
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	291,317,541.48	291,317,541.48
D08	Тайлант үеийн үр дүн			37,804,393.55	37,804,393.55
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	329,121,935.03	329,121,935.03

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	414,000,000.00	155,223,775.00	258,776,225.00	37.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,000,000.00	5,223,775.00	8,776,225.00	37.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,000,000.00	5,223,775.00	8,776,225.00	37.31
2104	Хангамж, бараа материалын зардал	1,200,000.00	1,100,000.00	100,000.00	91.67
210401	Бичиг хэрэг	400,000.00	400,000.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	800,000.00	700,000.00	100,000.00	87.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,800,000.00	4,123,775.00	8,676,225.00	32.22
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,800,000.00	4,123,775.00	8,676,225.00	32.22
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	400,000,000.00	150,000,000.00	250,000,000.00	37.50
230001	Эргэж төлөгдөх зээл	400,000,000.00	150,000,000.00	250,000,000.00	37.50
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	330,065,517.67	-	-
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	330,065,517.67	-	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	21,179,896.48	-	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	22,347,272.07	-	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	-	286,538,349.12	-	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	247,215,570.36	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	422,058,313.03	-	--



### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Хоршоо хөгжүүлэх сан нь Баян-Өндөр суманд үйл ажиллагаа эрхэлж байгаа хоршоодоор дамжуулан ажлын байр бий болгох, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, амьжиргааг сайжруулах, орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах зорилгоор улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр байгуулсан орон нутгийн тусгай сан юм.

Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны чиглэлийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тогтоолоор баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-д сумдад үйл ажиллагаа эрхэлж байгаа хоршоодоор дамжуулан ажлын байр бий болгох, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, амьжиргааг сайжруулах, орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах гэж тодорхойлжээ.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тус байгууллага нь тайланд онд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа дараах хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөн ажилласан байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тогтоолоор баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаал

Тайлант онд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хуулиас Төсвийн тухай хуульд 8 удаагийн нэмэлт өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Аймгийн Санхүү хяналт, дотоод аудитын албанаас 2023 оны сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, 4 зөвлөмж өгсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Өндөр сумын Хоршоо хөгжүүлэх сан нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.



Тус сан нь Орхон аймгийн Засаг даргын 2023 оны А/255 дугаар захирамжаар баталсан "Орхон аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг ашиглаж байна. Энэ нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баян-Өндөр сумын Хоршоо хөгжүүлэх сан нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 36,803.9 мянган төгрөгөөр буюу 3.0 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	247,216.6	422,058.3	174,841.7
Авлага	945,602.4	808,063.6	(137,538.8)
Бараа материал	499.0	0.0	(499.0)
Үндсэн хөрөнгө	0.0	0.0	0.0)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,193,318.0</b>	<b>1,230,121.9</b>	<b>36,803.9</b>
Өр төлбөр	901,000.0	901,000.0	0.0
Засгийн газрын хувь оролцоо	292,318.0	329,121.9	(36,803.9)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,193,318.0</b>	<b>1,230,121.9</b>	<b>36,803.9</b>

Дээрх хүснэгтээс харахад, нийт хөрөнгө өмнөх оноос 36,803.9 мянган төгрөгөөр өсөхөд мөнгөн хөрөнгө, авлага, бараа материалын данс нөлөөлжээ.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 422,058.3 мянган төгрөг болж 174,841.7 мянган төгрөгөөр өссөн нь зээлийн эргэн төлөлт болон тайланд онд зээл олголт буурснаас шалтгаалсан байна.

Авлагын дансны үлдэгдэл 808,063.6 мянган төгрөг болж 31,205.7 мянган төгрөгөөр буурсан нь зээлийн эргэн төлөлттэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэлгүй болж, 499.0 мянган төгрөгөөр буурсан нь бараа материал акталснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,230,121.9 мянган төгрөг болж 36,803.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээр ашигтай ажилласнаас шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт



Хоршоо хөгжүүлэх сангийн 2024 оны төсвийн төсөлд сангаас олгосон зээлийн хүүгийн өмнөх жилийн орлогын 45.6 хувийг буюу 14,000.0 мянган төгрөгийн зарлагыг гаргаж, 400,000.0 мянган төгрөгийн зээл олгохоор тооцон сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналын дагуу баталсан ба өөрчлөөгүй байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийг 414,000.0 мянган төгрөгөөр төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 72101 /Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих/ хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр баталсан байна.

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын 2024 оны А/103 дугаар захирамжаар төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталсан 2 хоршоонд нийт 150,000.0 мянган төгрөгийн зээл олгохоор шийдвэрлэсэн байна.

Тайлант онд үйл ажиллагааны зардалд 5,223.8 мянган төгрөг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 155,223.8 мянган төгрөг буюу 37.9 хувьтай байгаа нь урсгал зардлыг 8,776.2 мянган төгрөгөөр хэмнэж, зээл олгохоор баталсан төсвөөс 250,000.0 мянган төгрөгийн зээл олгоогүйтэй холбоотой байна. Зээл олголт буурсан нь 2 дах удаагийн төсөл сонгон шалгаруулалтад огт төсөл ирээгүйтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	/мянган төгрөг/		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>УЛСЫН ТӨСӨВ</b>				
1	72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих			
1.1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	14,000.0	5,223.8	8,776.2
1.2	80820 Бусад тусламж, дэмжлэг	400,000.0	150,000.0	250,000.0
				37.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн харилцах дансгүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд гадаад, дотоодын эх үүсвэрээс санхүүжих төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулах төсвийн зардал байхгүй байна.



## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон аймгийн Баян-Өндөр сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлэх, санхүүгийн бүртгэл, тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор В.Жавзмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Буян-Ундрах, дарга, тэргүүлэх аудитор П.Пүрэвхагва нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 2024 санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 48 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нийт хөрөнгө 1,193,318.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 17,899.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор сан хуулиар хориглож, хязгаарласан зэрэг нийт 31 асуудлаар хянаж, тулгахад хориглосон зардал гараагүй байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.



Баян-Өндөр сумын Хоршоо хөгжүүлэх сангийн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулах мэдээллийг Баян-Өндөр сумын Засаг даргын мэдээлэлд нэгтгэн тайлагнаж байна. Тайлант хугацаанд Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулах 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 150,000.0 мянган төгрөгийн 2 гүйлгээг мэдээлсэн байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Баян-Өндөр сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 2024 оны 1-3 дугаар улирлын санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгсөн 183,009.5 мянган төгрөгийн 3 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг санхүүгийн тайдангийн аудитын системд тайлагнасан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	0.0	-	0.0	-
Албан шаардлага	-	0.0	-	0.0	-
Зөвлөмж	3	183,009.5	3	183,009.5	100.0
Нийт дүн	3	183,009.5	3	183,009.5	100.0

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хугацаа хэтэрсэн зээлийн төлөлт, зээлийн явцын хяналт, хуулийн байгууллагад шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн зээлүүдийг дахин нягтлах.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,000.5 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 1,000.5 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

- Хоршоо хөгжүүлэх сангийн бүртгэл, хяналт, нэгтгэлийн системийн авлагын дүн, санхүүгийн тайланд тусгасан авлагын дүнг тохируулаагүй, зөрүүтэй тайлагнасан нь УСНББОУС 1, 2 болон аудитын иж бүрэн байх, оршин байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй тул санхүүгийн тайлан, тодруулгад тус тус залруулав.



Аудитаар нийт 14,776.8 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 14,776.8 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Аудитаар залруулаагүй зөрчилтэй асуудлаас 14,776.8 мянган төгрөгийн материаллаг зөрчил нь тогтоосон материаллаг байдлын дүнгээс бага байгаа тул өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн болно.

## **5.1 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **1. Авлагын данстай холбоотой асуудал**

#### **Илрүүлэлт:**

Сангаас 2022-2024 онд олгосон зээлээс 4 зээлдэгч зээлийн гэрээний үүргийн биелэлтийг хангуулаагүй, үндсэн зээлийн төлбөрийн 14,776,844 төгрөгийн төлөлт хийгээгүй хугацаа хэтэрсэн байна.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалаар баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 10.1-д "Хяналтын зөвлөл нь зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт, зээлийн хүү, алдангийг тухай: бүр төлүүлж буйд хяналт тавина", 10.4-т "Зээлдэгч нь зээлийг гэрээнд заасан хугацааны дотор эргэн төлөх үүргээ биелүүлээгүй тохиолдолд жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь чанаргүй активын ангилалд оруулж, Монгол банкны зээлийн мэдээллийн санд чанаргүй зээлдэгчийн ангилалд бүртгэнэ", 10.5-д "Зээлдэгчийн гэрээнд эрсдэл үүссэн тохиолдолд зээлийн хөрөнгийг эргүүлэн татах ажиллагааг сумын Засаг дарга болон хяналтын зөвлөл хариуцан зохион байгуулна. Энэхүү зохицуулалтыг зээлийн гэрээгээр нарийвчлан зохицуулна", 11.1-д "Сангаас зээл авсан этгээд зээлийг үр ашиггүй зарцуулсан буюу зориулалтын дагуу зарцуулаагүй, зээлийн болон барьцааны гэрээгээр хүлээсэн үүргээ биелүлдээгүй тохиолдолд тухайн этгээдэд олгосон хөнгөлөлттэй зээлийг буцаан төвлөрүүлэх бөгөөд сангаас дахин зээл олгохгүй" гэж заасантай нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Өгсөн зөвлөмж 1:**

Зээл төлөлтийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу хянаж, эрсдэл үүссэн тохиолдолд журмын дагуу арга хэмжээ авч ажиллах.

### **2. Авлагын данстай холбоотой асуудал**

#### **Илрүүлэлт:**

Сангаас 2011-2021 онд олгосон хуулийн байгууллагад шилжсэн 27 зээлдэгчийн шийдвэрийг хэрэгжилтийг хангуулах талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албатай хамтран ажиллаагүй байна.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалаар баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 10.5-д "Зээлдэгчийн гэрээнд эрсдэл үүссэн тохиолдолд зээлийн хөрөнгийг эргүүлэн татах ажиллагааг сумын Засаг дарга болон хяналтын зөвлөл хариуцан зохион байгуулна. Энэхүү зохицуулалтыг зээлийн

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.



гэрээгээр нарийвчлан зохицуулна", 11.1-д "Сангаас зээл авсан этгээд зээлийг үр ашиггүй зарцуулсан буюу зориулалтын дагуу зарцуулаагүй, зээлийн болон барьцааны гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд тухайн этгээдэд олгосон хөнгөлөлттэй зээлийг буцаан төвлөрүүлэх бөгөөд сангаас дахин зээл олгохгүй" гэж заасантай нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж 2:**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албатай хамтран ажиллаж, хуулийн байгууллагад шилжсэн 27 зээлдэгчийн шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛГИЙН НЭГТГЭЛ**  
**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/Мянган төгрөг/												
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Үүнээс		Зөвлөмж										
							Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн									
Хоршоо хөржүүлэх сангийн бүртгэл, хяналт, нэгтгэлийн системийн авлагын дүн, санхүүгийн тайланд тусгасан авлагын дүнг тохируулаагүй, дүнг зөрүүтэй тайлагнасан.	1	1,000.5			1	1,000.5	1	1,000.5											
Дүн	1	1,000.5			0.0	1	1,000.5	1	-1,000.5			0.0							0.0

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сангаас 2022-2024 онд олгосон зээлээс 4 зээлдэгч зээлийн гэрээний үүргийн биелэлтийг хангуулаагүй, үндсэн зээлийн төлбөрийн төрөгийн төлөлт хийгээгүй хугацаа хэтэрсэн.	1	14,776.8					1	14,776.8				
Сангаас 2011-2021 онд олгосон хуулийн байгууллагад шилжсэн 27 зээлдэгчийн шийдвэрийг хэрэгжилтийг хангуулах талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албатай хамтран ажиллаагүй байна.	1						1					
Дүн	2	14,776.8		0.0		0.0	2	14,776.8		0.0		0.0



**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил		0.0		0.0		0.0		0.0
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил		0.0		0.0		0.0		
Дүн		0.0		0.0		0.0		0.0
<b>Нийт дүн</b>								